

Олон улсын Театрын өдөр 2018 – Арабын орнууд

Маяа Збиб, Лебанон улс

Театрын найруулагч, жүжигчин, зохиолч, Зоукак Театр компаний үүсгэн байгуулагчдын нэг

Ойр дотно харилцаа, дахин давтагдашгүй учрал, энэ бүхнийг нийгмийн бусад үйл ажиллагаануудаас олохгүй. Энэ бол өөрсдийн ижил төстэй туршлагыг хуваалцахаар нэгэн цагт нэг газар хүсэл сэтгэлээрээ нэгдэн цуглахаар шийдсэн бүлэг хүмүүсийн энгийн нэг үйлдэл. Энэ бол хувь хүнийг нэгдэхийг, санаа бодлоо хуваалцаж, зайлшгүй хийвэл зохих үйл хэргийг хэрхэн хамтран гүйцэлдүүлэх арга замуудыг ... өөр хоорондоо ялгаатай байдлаа бус харин ижил төстэй байдлаа олж хараад хүн төрөлхтний харилцан холбогдох мөн чанарыг аажмаар сэргээхийг уриалсан урилга. Энэ бол тодорхой нэгэн түүхийг судалсаар нийтлэг байдлыг илрүүлж болно гэсэн үг... Үүнд л театрын ид шид оршин байдаг. Бүтээл нь өнө эртний мөн чанарыг сэргээдэг.

Нэг нэгнээсээ айх, тусгаарлагдан ганцаардмал байдал газар авсан даяаршлын соёл биднээс цуглан нэгдэхийг, дотоод сэтгэлээрээ нэгдмэл болохыг яг энд, одоо шаардаж байгаа нь хайрын үйлдэл юм. Хэрэглэгчид хөтлөгдсөн, түргэн хэмнэлтэй нийгэмд өөрийгөө өөгшүүлж, түргэн нэр алдарт хүрэх гэж зүтгэхийн оронд цаг гаргахаар шийдэн, алхаагаа удаашруулаад эрэгцүүлэн бодож тунгаах нь улс төрийн үйлдэл, өгөөмөр сэтгэлийн гүнээс гарах үйлдэл юм.

Голлох үзэл суртал нуран унасны дараагаар бидний нийгмийн аливаа бүх дараалал журам арав арван жилээр нуран унаж улам бүр сүйрсээр байна. Бид хэрхэн ирээдүйгээ дахин цоо шинээр төсөөлөх вэ? Бодолд хамгийн түрүүнд аюулгүй байдал, тав тухтай байдал түрэн орж ирж байхад бид хэрэн таагүй зүйлсийн талаар яриад байж чадах вэ? Давуу эрх дархаа алдах айдасгүйгээр бид аюултай газар нутгийг зорин хил хязгаарыг нь давж чадна гэж үү?

Өнөөдөр, мэдээллийн хурд мэдлэгээс илүү чухал, уриа лозунг үг хэлнээс илүү үнэ цэнэтэй, хүний жинхэнэ бие махбодоос илүүтэй зураг дүрсийг нь дээдлэн биширдэг болжээ. Театр бидэнд бид бол махан бие, цуснаас бүтсэн бөгөөд бидний биед тодорхой жин бий гэдгийг одоо сануулж байна. Бидний бүхий л мэдрэхүйг сэрээж, зөвхөн харах эрхтэндээ захирагдан харсан болгоноо сарвайн авч хэрэглэх шаардлагагүй гэдгийг сануулж байна. Театр бидэнд үгийн утга болоод хүчийг эргүүлэн өгч, бодол эрэгцүүллийг улс төрчдөөс буцаан авч зүй ёсны байр сууринд тавихыг ... санаа бодол ба мэтгэлцээн, хамтдаа алсын хараа зорилгоо бий болгох тэр л орон зайд аваачихыг сануулж байна.

Үлгэр, тууль хайлах увдис болон төсөөллийн ачаар театр бидэнд дэлхий ертөнц болоод бие биенээ шинээр, өөрөөр харах мэлмийг нээж, үл тэвчих байдал болоод үл ойшоох үзэл давамгайлсан энэ нийгэмд хамтдаа бодож

эрэгцүүлэх орон зайг нээн өгч байна. Гадаад хүнийг үзэн ядах үзэл, үзэн ядсан үг яриа болоод цагаан арьстны дээд эрх мэдэл гээд ямар ч чармайлт гаргалгүйгээр бидний ширээнд заларчихлаа, гэтэл олон арван жил хүмүүс амиа золиослон байж эдгээрийг байж боломгүй зүйлс агаад ийм үйлдэл хийсэн этгээд ичгүүрт хэрэг хийсэн этгээд гэдгийг ойлгуулах гэж тэмцэж ирсэн... Өсвөр насны охид, хөвгүүд толгойдоо буудуулж, шударга бус байдал болон арьс өнгөөр ялгаварлан гадуурхахаас татгалзсаныхаа төлөө шоронд хоригдож байна... Өндөр хөгжсөн орнуудын төрийн жолоог солиорлын бэлгэ тэмдэг болоод баруун жигүүрийн дарангуйлагч этгээдүүд барин удирдаж байна... Цөмийн дайны эрх виртуал ертөнц дэх насанд хүрсэн-хүүхдийн тоглоом мэт гарт нь байна... Хүмүүсийн шилжих хөдөлгөөнийг улам бүр хязгаарлаж, цөөн хэдэн хүн л эрх эдэлж байхад цаана нь дүрвэгсэд хуурмаг итгэл найдварын цамхаг руу орох гэж яваад далайд живж байна, гэтэл улам л илүү үнэтэй хана саадыг босгосоор... Ихэнх хэвлэл мэдээлэл худалдагдчихсан байхад бид дэлхийд болж буй бүхний асуултыг хаанаас асуух вэ? Хамтаараа хайр болоод энэрэнгүй сэтгэл, оюун ухаан, сэтгэлийн хат болоод хүч чадлаа шавхан байж хүн төрөлхтний нөхцөл байдлаа дахин эрэгцүүлж бодох, шинэ ертөнцийн дэг журам, эмх замбарааг төсөөлөх тийм газар бидэнд театраас өөр хаана ч байхгүй.

Арабын улс орнуудыг төлөөлж байгаагийн хувьд би уран бүтээлчдийн даван туулж буй бэрхшээлүүдийн талаар ярьж чадна. Гэхдээ би бол бидний устгах ёстой хана үргэлж нүдэнд харагдах ил хана байсан давуу эрхийг эдэлсэн уран бүтээлчдийн үеийн хүн. Энэ нь бидэнд байгаагаа ашиглаж, хамтран нэгдэж, бүтээлч санаачлагын эцсийн туйлд нь хүртэл явахад сургасан. Бид театрын байшингийн суурийн хонгилд, дээвэр дээр, айлын зочны өрөөнд, гудамжинд, булан тохойд бий болгон үзэгчдийнхээ хамт хот, тосгон, дүрвэгсдийн хуаранд хүртэл театр бий болгож байсан. Бид агуулгын хувьд юу ч үгүй хоосноос бүгдийг бий болгож бүтээх гэдэг давуу тал байсан, ингэснээрээ цензурдах оролдлогоос зайлсхийх арга замуудыг олдог байв, ингэх бүртээ бид улаан шугамыг давж, хорио цээрийг үгүйсгэж чаддаг байв. Өнөөдөр эдгээр хана театрын бүх уран бүтээлчдэд дэлхий дахинаа тулгараад байна, улс төрийн үзэл одоогийн шинэ цензур болж, бүтээл туурвихад зориулах хөрөнгө улам бүр хомс болж байна.

Тиймд, олон улсын театр хэмээх хамт олон бид хамт олноороо эдгээр биет болоод биет бус ханануудтай нүүр тулан тэмцэхэд урьд урьдынхаас илүү их үүрэг хариуцлагыг хүлээж байна. Хамтдаа бид шударга ёсыг баримтлан эр зоригтойоор нийгмийн болоод улс төрийн бүтэц, байгуулалтыг дахин шинээр нээхийн төлөө ажиллах хэрэгтэй байна. Алдаа гажуудлыг илчлэн харуулахын тулд, өөрсдийн шинээр бий болгохыг хүсч буй нийгмийнхээ эд эсийн хувьд. Дэлхийн театрын уран бүтээлчийн хувьд, бид ямар нэгэн үзэл суртал эсвэл итгэл үнэмшлийг туйлын үнэн мэт дагахгүй, харин бид урлагийн бүхий л төрлөөр дамжуулан мөнхийн үнэнийг, өөрсдийн эзлэх байр суурийн талаарх, дарангуйлагч хүчний тогтолцоог сорих зэрэг дуусашгүй асуултуудын хариуг,

ямартаа ч хүн төрөлхтний мөн чанар, бүрэн бүтэн байдлыг эрэлхийлэх
нэгдмэл хүсэл эрмэлзлээрээ нэгддэг.

Бид олуулаа, бидэнд айх айдас байхгүй, бид энд өнөөдөр оршин байсаар байх
болно!

Орчуулсан Н. Болороо